



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 9/55

Улаанбаатар хот

### Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>2</sup> дугаар зүйлийн 5<sup>2</sup>.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/1240 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1240 дүгээр захирамжийн дагуу нийтийн байрны барилга байгууламжийн хийц бүтээц (цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, барилгын материал) стандарт, норм дүрмийн хэрэгжилт аюулгүй байдал хангаж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх албан хаагчдын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс (Б.Найрамдал), Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс (Г.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Удирдамжийн дагуу илүү цагаар ажиллах нөхцөлд холбогдох дүрэм, журмын дагуу илүү цагийн тооцоог хянаж олгохыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

